



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

Багшийн хөгжлийн ордон, Энхтайваны өргөн чөлөө 10а,
11 дүгээр хороолол, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191
Утас/Факс: (976) 7011-3033
<http://www.edub.edu.mn>

2019.05.27 № 04/837
танай _____-ны № _____-т

ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА НАРТ

Нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн халдварт өвчнөөс сэргийлэх, хариу арга хэмжээ авах тухай зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна. Зөвлөмжийг нэгж байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллана уу.

Хавсралт 3 хуудас

ХШҮХ-ИЙН ДАРГА *С.Ганчимэг* С.ГАНЧИМЭГ



1110800888



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Хангарди ордон, Нийслэлийн засаг захиргааны II байр,
Ц.Жигжиджавын гудамж-9, Бага тойруу-3,
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-11) 32-50-76
E-mail: ubhd@emg.ub.gov.mn, http://www.ubhealth.mn

2019.05.22 № 1/438

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНТУЛГА ТАНАА

Сүүлийн жилүүдэд зарим хүүхдийн байгууллагад сүрьеэ, хоолны хордлогот халдварт өвчин голомтлох болон дэгдэлт байдлаар гарч байгаа тул цаашид халдварт өвчин гарах, тархахаас сэргийлэх чиглэлээр хүүхдийн байгууллагууд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагатай болоод байна.

Иймд халдварт өвчнөөс сэргийлэх, хариу арга хэмжээ авах зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна. Зөвлөмжийг сургууль, цэцэрлэгийн байгууллагад хүргэж, хэрэгжилтэнд хяналт тавьж, бидэнтэй хамтран ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

1150500468

ЗӨВЛӨМЖ

ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАД:

1. Анги дүүргэлтийн норм нормативыг мөрдөж ажиллах, хэт төвлөрөл үүсгэхгүй, ээлжээр хичээллүүлэн анги танхимд агаар сэлгэлтийг хийх нөхцлийг бүрдүүлэх,

2. Анги, бүлэг, биеийн тамирын заал, хонгил зэрэг өрөө, тасалгаа бүрийн агааржуулалт, гэрэлтүүлэг, дулаан хангамж, угаалтуур, суултуурын хүрэлцээнд хяналт тавьж, шаардлагатай завсар үйлчилгээ, хангалтыг хийн эрүүл ахуйн стандарт, шаардлагыг хангах,

3. Хэт ягаан туяаны гэрэл болон шаардлагатай ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлэх,

4. Гал тогоо, цайны газарт эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийн шаардлагыг хэрэгжүүлж, хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах,

5. Шинэ хичээлийн жил эхлэхийн өмнө хүүхдийн байгууллагын багш, ажилтан албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамруулах, хамралтын байдалд хяналт тавих,

6. Өвчлөлийн дэгдэлтийн ид үед багш, ажилчид, суралцагч, хүмүүжигч нарын дархлааг дэмжих, аминдэмжүүлэх, чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, үр дүнг тооцох,

7. Халдварт өвчин бүртгэгдсэн тохиолдолд хавьтлын өргөжүүлсэн судалгаа, ирлүүлгийн үзлэг шинжилгээ, эмчилгээг зохион байгуулахад эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах,

8. Багш, ажилчдаас халдварт өвчнөөр өвдсөн тохиолдолд өвчнөө эмчлэн эдгэрүүлэхэд нь дэмжлэг үзүүлж холбогдох заавар, журмын дагуу ажлаас түр чөлөөлөх, ажлын байрыг хадгалах, нууцыг хадгалан ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх, бусад ажилчдад зөв ойлголтыг өгч эерэг хандлага бий болгох арга хэмжээг зохион байгуулах

9. Багш, эмч, үйлчилгээний ажилчдыг ариутгал, халдваргүйтгэл хийх сургалтад хамруулан мэдлэг олгох, анги, танхимын их цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийг 10-14 хоног тутамд тогтмол хийж, дотоодын хяналтыг хийж хэвших

АНГИ УДИРДСАН БАГШ НАРТ:

1. Сурагчдын ирцийн тандалтыг өдөр бүр идэвхтэй хийж, өвчний зовиур, шинж тэмдэг илэрч байгаа хүүхдийг эмчид мэдэгдэн үзлэг хийлгэж, шаардлагатай бол хичээлээс нь чөлөөлж, эцэг эхэд нь мэдээлэх,

2. Хүүхдэд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, зөвлөгөөг тогтмол өгч, гар угаах, нус цэрээ ил задгай хаяхгүй байх, зөв ханиах найтаах, амны хаалт хэрэглэх, дадал хэвшлийг эзэмшүүлэх сургалтыг эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран хичээлийн жилийн турш тогтмол явуулах,

3. Анги танхим, бусад өрөө тасалгааны салхивчийг 2 цаг тутамд 15 минутаас доошгүй хугацаагаар нээн агаар оруулж агаар сэлгэлтийг тогтмол хийх, чийгтэй цэвэрлэгээг ээлж бүрийн хооронд хийж хэвших,

4. Амьсгалын замын дэгдэлт бүртгэгдсэн тохиолдолд агаарыг халдваргүйжүүлэх зорилгоор хэт ягаан туяаны гэрлийг өдөрт 2-3 удаа 15-20 минутаар асааж, халдваргүйтгэн, тэмдэглэл хөтлөх,

ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭМЧ, НИЙГМИЙН АЖИЛТАН НАРТ:

1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах,

2. Өдөр бүр ирцийн тандалтын мэдээг авч шаардлагатай хүүхдэд үзлэг хийн холбогдох арга хэмжээг авч ажиллах,

3. Багш, ажилчдыг 6 сар тутамд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулж, хамрагдалтын байдалд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангах,

4. Халдварт өвчний сэжигтэй шинж тэмдэг илэрсэн тохиолдолд бүртгэл хөтөлж харьяа эрүүл мэндийн байгууллагад мэдээлэх,

5. 6 сар тутамд хийгдэж байгаа ариутгал халдваргүйтгэлийн чанарт хяналт тавих, мөн халдварт өвчин гарсан тохиолдолд голомтод арга хэмжээг авч хэрэгжилтийг холбогдох байгууллагад хүргүүлэх,

6. Халдварт өвчний улмаас эмчилгээнд хамрагдаж буй суралцагчдын эмчилгээ, эдгэрэлтийн явцад хяналт тавих, эдгэрсэний дараа эцэг эхэд зөвлөгөө өгч хамтран ажиллах

7. Харьяалах дүүргийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг байгууллагын хэмжээнд тогтмол хийх,

8. Эрүүл мэндийн байгууллагаас хийж буй урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллах,

9. Анги, танхим, өрөө тасалгааны ариун цэвэр, халдваргүйтгэлийн байдалд тогтмол хяналт тавин, арга зүйгээр хангах.